

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны -р сарын -ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Захиалгат цутгамал хийц алхан бутлагч”-ийг сонгон шалгаруулах тендер.

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2020-121**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Захиалгат цутгамал хийц алхан бутлагч” нийлүүлэгчийн тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцохгүй”

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2018, 2019 он/
- 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- 3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага:** Сүүлийн 2 жил буюу /2018, 2019 /онуудын жилийн дүн нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байна.
- 4. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** аудитлагдсан тайлан сүүлийн 2 жил. /2018, 2019 тус бүрээр/

Тендерийн хамт төсөвт өртгийн 2%-тай тэнцэх 1,803,960 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа: 2020 оны 5 дугаар сарын 08-ны өдөр хүртэл

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 -р хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Утас: 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс: 7018-1309, 7000-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



МӨМӨРХУЯГ/